



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/226

Мандатгүй

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1.6, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын 2021 оны хамтран ажиллах гэрээний 3 дугаар хавсралтын 1.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөвт байгууллагуудын удирдлагуудад төрийн албаны хуулийг шинэ агуулгаар хэрэгжүүлэхэд ач холбогдолтой эрх зүйн баримтыг хэрэгжүүлэх зөвлөгөө, мэдээллийг эмхтгэн найруулсан “Төрийн албан шинэтгэлд шимтэхийн учир” номыг олгож дэмжлэг үзүүлсүгэй.

2. Төрийн албаны тухай хууль, холбогдох тогтоол, журмуудыг сурталчилан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, албан хаагчдыг мэдээллээр хангаж ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 490,000 (дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ